



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/09

Номгон


Согтууруулах ундаа худалдах тусгай
зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 15 дугаар зүйлийн 15.3, 15¹.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар “ББМАГ шанд” ХХК, “Тоть нуурын ундарга” ХХК-наас хүсэлт ирүүлсний дагуу Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Баян-Өндөр сумын Э.Гарамханд эзэнтэй Эх шанд, Галуут сумын Б.Зоригтбаатар эзэнтэй Баянхонгор хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2029 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн эздэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав), аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

842311971